



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: АРА-2022/97/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdeneg@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Агуулга

1.Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	13
4. Аудитын илрүүлэлт .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№/Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,271,056.31	4,861,000
2 АВЛАГА	410,056.31	
3 Ажиллагчидтай холбогдсон авлага	410,056.31	
4 БАРАА МАТЕРИАЛ	4,861,000	4,861,000
5 Хангамжийн материал	4,861,000	4,861,000
6 Бичиг хэргийн материал	2,311,300	2,311,300
7 Аж ахуйн материал	1,724,700	1,724,700
8 Барилгын засварын материал	825,000	825,000
9 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	336,891,124.6	329,254,655.34
10 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	336,891,124.6	329,254,655.34
11 Биет хөрөнгө	333,453,124.6	325,816,655.34
12 Барилга, байгууламж, орон сууц	338,442,783	338,442,783
13 Хуримтлагдсан элэгдэл	-32,514,513.6	-46,062,227.6
14 Машин тоног төхөөрөмж(компьютер)	26,209,082.6	34,448,132.6
15 Хуримтлагдсан элэгдэл	-19,266,366.33	-20,653,665.97
16 Тавилга, аж ахуйн эд хогшил	18,184,498.11	18,184,498.11
17 Хуримтлагдсан элэгдэл	-15,578,473.18	-16,518,978.8
18 Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,000,000	8,000,000
19 Бусад үндсэн хөрөнгө	1,224,367.38	1,224,367.38
20 Хуримтлагдсан элэгдэл	-1,224,367.38	-1,224,367.38
21 Ном	9,976,114	9,976,114
22 Биет бус хөрөнгө	3,438,000	3,438,000
23 Бусад биет бус хөрөнгө	3,438,000	3,438,000
24 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	342,162,180.91	334,115,655.34
25 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	342,162,180.91	334,115,655.34
26 Засгийн газрын хувь оролцоо	342,162,180.91	334,115,655.34
27 Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	119,003,287.6	119,003,287.6
28 Хуримтлагдсан үр дүн	61,864,208.03	53,817,682.46
29 Өмнөх үеийн үр дүн	64,162,572.92	61,864,208.03
30 Тайлант үеийн үр дүн	-2,298,364.89	-8,046,525.57
31 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	161,294,685.28	161,294,685.28
32 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	342,162,180.91	334,115,655.34

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	167,281,126	168,199,550
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,089,226	8,239,050
3	Нийтлэг татварын бус орлого	16,089,226	8,239,050
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	705,000	
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	705,000	
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,384,226	8,239,050
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,191,900	159,960,500
8	Нэмэлт санхүүжилтийн орлого	408,500	2,153,500
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,500	2,153,500
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,783,400	157,807,000
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,783,400	157,807,000
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	169,579,490.89	176,246,075.57
13	УРСГАЛ ЗАРДАЛ	169,579,490.89	176,246,075.57
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149,522,805.89	173,426,788.39
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,995,977	57,805,051
16	Үндсэн цалин	54,995,977	57,805,051
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,416,521.69	7,426,278.13
18	Тэтгэврийн даатгал	4,674,657.65	5,644,479.09
19	Тэтгэмжийн даатгал	549,959.71	484,026.47
20	ҮОМШӨ-ний даатгал	439,960.13	387,221.56
21	Ажилгүйдлийн даатгал	105,636.53	82,246.65
22	Эрүүл мэндийн даатгал	646,307.67	828,304.36
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,735,200	86,880,200
24	Гэрэл, цахилгаан	1,700,000	1,700,000
25	Түлш, халаалт	64,935,200	85,135,200
26	Цэвэр, бохир ус	100,000	45,000
27	Хангамж, бараа материалын зардал	697,775	581,980
28	Бичиг хэрэг	71,975	66,200
29	Тээвэр, шатахуун	282,300	281,080
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,000	49,100
31	Ном, хэвлэл	110,200	66,300
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	219,300	113,800
33	Аж ахуйн материал худалдан авах зардал		5,500
34	Нормативт зардал	49,000	49,000
35	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000	49,000
36	Эд хогшил, урсгал засварын зардал		2,253,500
37	Урсгал засвар		2,253,500
38	Томилолт, зочны зардал		48,000
39	Дотоод албан томилолт		48,000
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,591,260	2,507,260
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,484,000	2,400,000
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000	80,000
43	Газрын төлбөр	27,260	27,260
44	Бараа үйлчилгээний бусад зардал	19,037,072.2	15,875,519.26
45	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,037,072.2	15,875,519.26
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,056,685	2,819,287.18
47	Бусад урсгал шилжүүлэг	19,268,300	438,000
48	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,155,200	
49	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,113,100	438,000

50	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	788,385	2,381,287.18
51	Төвлөрүүлэх шилжүүлэг	788,385	2,381,287.18
52	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,298,364.89	-8,046,525.57
53	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,298,364.89	-8,046,525.57

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	64,162,572.92	344,460,545.8
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	64,162,572.92	344,460,545.8
3	Тайлант үеийн үр дүн			-2,298,364.89	-2,298,364.89
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	61,864,208.03	342,162,180.91
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	61,864,208.03	342,162,180.91
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	61,864,208.03	342,162,180.91
7	Тайлант үеийн үр дүн			-8,046,525.57	-8,046,525.57
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	119,003,287.6	161,294,685.28	53,817,682.46	334,115,655.34

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	151,896,900	159,960,500
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	705,000	
3	Нийтлэг татварын бус орлого	705,000	
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	705,000	
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	705,000	
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	151,191,900	159,960,500
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	408,500	2,153,500
8	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	408,500	2,153,500
9	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,783,400	157,807,000
10	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,783,400	157,807,000
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	151,896,900	159,960,500
12	УРСГАЛ ЗАРДАЛ	151,896,900	159,960,500
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	131,840,215	157,141,212.82
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	54,995,974	57,805,051
15	Үндсэн цалин	54,995,974	57,805,051
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,826,581	7,016,221.82
17	Тэтгэврийн даатгал	4,678,133	5,234,422.78
18	Тэтгэмжийн даатгал	548,708	484,026.47
19	ҮОМШӨ-ний даатгал	439,445	387,221.56
20	Ажилгүйдлийн даатгал	105,635	82,246.65
21	Эрүүл мэндийн даатгал	1,054,660	828,304.36
22	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,735,200	86,880,200
23	Гэрэл, цахилгаан	1,700,000	1,700,000
24	Түлш, халаалт	64,935,200	85,135,200
25	Цэвэр, бохир ус	100,000	45,000
26	Хангамж, бараа материалын зардал	604,400	581,980
27	Бичиг хэрэг	66,500	66,200
28	Тээвэр, шатахуун	282,300	281,080
29	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000	49,100
30	Ном, хэвлэл	66,300	66,300
31	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300	119,300
32	Нормативт зардал	49,000	49,000
33	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000	49,000
34	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000	2,253,500
35	Урсгал засвар	100,000	2,253,500
36	Томилолт, зочны зардал		48,000
37	Дотоод албан томилолт		48,000
38	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,529,060	2,507,260
39	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,421,800	2,400,000
40	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000	80,000
41	Газрын төлбөр	27,260	27,260
42	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,056,685	2,819,287.18
43	Бусад урсгал шилжүүлэг	19,268,300	438,000
44	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,155,200	
45	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,113,100	438,000
46	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	788,385	2,381,287.18
47	Төвлөрүүлэх шилжүүлэг	788,385	2,381,287.18

48	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
49	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,807,000	155,425,712.82	2,381,287.18	98.5
2	УРСГАЛ ЗАРДАЛ	157,807,000	155,425,712.82	2,381,287.18	98.5
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,368,200	154,987,712.82	2,380,487.18	98.5
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,996,500	57,805,051	1,191,449.00	98.0
5	Үндсэн цалин	58,996,500	57,805,051	1,191,449.00	98.0
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,964,500	7,016,221.82	948,278.18	88.1
7	Тэтгэврийн даатгал	5,604,600	5,234,422.78	370,177.22	93.4
8	Тэтгэмжийн даатгал	590,000	484,026.47	105,973.53	82.0
9	ҮОМШӨ-ний даатгал	472,000	387,221.56	84,778.44	82.0
10	Ажилгүйдлийн даатгал	118,000	82,246.65	35,753.35	69.7
11	Эрүүл мэндийн даатгал	1,179,900	828,304.36	351,595.64	70.2
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,935,200	86,880,200	55,000.00	99.9
13	Гэрэл, цахилгаан	1,700,000	1,700,000	-	100.0
14	Түлш, халаалт	85,135,200	85,135,200	-	100.0
15	Цэвэр, бохир ус	100,000	45,000	55,000.00	45.0
16	Хангамж, бараа материалын зардал	604,400	581,980	22,420.00	96.3
17	Бичиг хэрэг	66,500	66,200	300.00	99.5
18	Тээвэр, шатахуун	282,300	281,080	1,220.00	99.6
19	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000	49,100	20,900.00	70.1
20	Ном, хэвлэл	66,300	66,300	-	100.0
21	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300	119,300	-	100.0
22	Нормативт зардал	49,000	49,000	-	100.0
23	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000	49,000	-	100.0
24	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000	100,000	-	100.0
25	Урсгал засвар	100,000	100,000	-	100.0
26	Томилолт, зочны зардал	70,600	48,000	22,600.00	68.0
27	Дотоод албан томилолт	70,600	48,000	22,600.00	68.0
28	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000	2,507,260	140,740.00	94.7
29	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500	2,400,000	22,500.00	99.1
30	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000	80,000	-	100.0
31	Газрын төлбөр	145,500	27,260	118,240.00	18.7
32	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800	438,000	800.00	99.8

33	Бусад урсгал шилжүүлэг	438,800	438,000	800.00	99.8
34	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800	438,000	800.00	99.8
35	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,807,000	155,425,712.82	2,381,287.18	98.5
36	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	157,807,000	155,425,712.82	2,381,287.18	98.5
37	Орон нутгийн төсвөөс	157,807,000	155,425,712.82	2,381,287.18	98.5
38	АЖИЛЛАГСАДЫН ТОО	6	6	6.00	100.0
39	Удирдах ажилтан	1	1	1.00	100.0
40	Гүйцэтгэх ажилтан	4	4	4.00	100.0
41	Үйлчлэх ажилтан	1	1	1.00	100.0
42	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6	6.00	100.0
43	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6	6	6.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,153,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,153,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,153,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,153,500.00
210604	Урсгал засвар	2,153,500.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,153,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,153,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,153,500.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хайрхан сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайрхан сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20 -ны өдрийн 2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хайрхан сумын Соёлын төв нь ард иргэдэд соёл урлаг, олон нийтийн арга хэмжээг зөв боловсон хүргэж, хүүхэд залуучуудын авъяас билгийг нээн илрүүлж, олныг хүртээл болгох мөн соёлын үйлчилгээний цар хүрээг өргөтгөж соёлын стандартын шаардлагыг хангах зорилготой соёл урлагын үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн төсвөөс санхүүждэг, төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Хүн амын тодорхой хэсгийн чөлөөт цагийг үр ашигтай зохион байгуулснаар соёл, урлагын хөгжилд хувь нэмэр оруулах, чанартай хүртээмжтэй үйлчилгээг эрхэмлэх” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулсан байна. Харин санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгж нь байгууллагын болон санхүү төсвийн үйл ажиллагаатай холбоотойгоор 12 чиглэлээр хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж үр дүнг тооцож ажилласан байгаа нь дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хайрхан сумын Соёлын төв нь Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дүгээр тушаалаар батлагдсан Соёлын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайрхан сумын Соёлын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 157.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 1.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 8.05 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан нь материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Авлага	0.41	-	(0.41)	-
Бараа материал	4.86	4.86	-	-

/сая төгрөгөөр/

Үндсэн хөрөнгө	336.89	329.25	(7.64)	(2.27)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>342.16</b>	<b>334.12</b>	<b>(8.05)</b>	<b>(2.35)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	342.16	334.12	(8.05)	(2.35)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>342.2</b>	<b>334.1</b>	<b>(8.0)</b>	<b>(2.4)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 4.8 сая төгрөг байна.

Бараа материалын данс нь 4.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 0.56 сая төгрөг нэмэгдэж, тайлант онд 0.56 сая төгрөгийн зарцуулалт гарч, 4.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 2.3 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 336.8 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 8.2 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 15.8 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 334.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 8.05 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт /төгрөгөөр/
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	150.78	157.81	7.02
Нэмэлт санхүүжилтийн орлого	0.41	2.15	1.75
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15.38	8.24	(7.15)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.71	-	(0.71)
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>167.28</b>	<b>168.20</b>	<b>0.92</b>
Цалин, шимтгэлийн зардал	61.41	65.23	3.82
Бусад бараа үйлчилгээний зардал	88.11	108.20	20.09
Урсгал шилжүүлэг	20.06	2.82	(17.24)
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>169.58</b>	<b>176.25</b>	<b>6.67</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(2.30)</b>	<b>(8.05)</b>	<b>(5.75)</b>

Хайрхан сумын Соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оны мөн үеэс 7.0 сая төгрөгөөр өссөн нь цалин, шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 7.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 202.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 44.7 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 157.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 157.8 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 155.4 сая төгрөгийг зарцуулж, 2.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас Соёлын төвийн дээврийн засварын ажилд 2.1 сая төгрөг ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус Соёлын төв нь 2021 онд шинээр батлагдсан Ковид-19 цар тахлын үед улс, аймаг сумын онцгой комиссоос аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгааны дагуу соёл урлагийн үйлчилгээг хориглосны улмаас соёл урлагийн болон олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Мөн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой Соёлын тухай хуулийг 2021 оны 7 дугаар сарын 02-ний өдөр шинэчлэн найруулга батлагдаж 2022 оноос дагаж мөрдөж байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 90 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 157.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 9.5 хувь буюу 3.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хайрхан сумын Соёлын төв нь 2021 онд 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 109 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаарлага өгөө.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Тухайн тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 9.5% буюу 3.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 35.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 30.6 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

##### 4.1 Албан шаардлага

- Тус байгууллагын төсөв захирагчид 2021 оны 4, 5, 6, 7 дугаар саруудад ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтөлж Төсвийн ерөнхийлөн захирагчаар баталгаажуулахгүйгээр, тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн илүү цагийн хөлс 770.8 мянган төгрөгийг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, МУЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дахь заалт, тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.3, 3.4 дэх заалтыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

##### 4.3 Зөвлөмж

###### 1. Илүү цагтай холбоотой асуудал

Тайлант онд албан хаагчдад илүү цагийн хөлс тооцож олгох хуудас хөтөлж баталгаажуулаагүй 2,252.4 мянган төгрөгийг олгосон байна.

###### Өгсөн зөвлөмж:

МУЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1, 3.4 дэх заалтын дагуу илүү цагийн хөлс тооцож олгох хуудас хөтөлж ажиллах

###### 2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 303 нэр төрлийн 28.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "НББ-ийн дансны заавар"-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэхь заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	Хайрхан сумын СТөв	Тус байгууллагын төсөв захирагчид 2021 оны 4, 5, 6, 7 дугаар саруудад ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг хөтөлж Төсвийн ерөнхийлөн захирагчаар баталгаажуулахгүйгээр, тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрүүлэн илүү цагийн хөлс 770.8 мянган төгрөгийг олгосон байна.	1	0.7					1	0.7		
2		Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 303 нэр төрлийн 28.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	28.4							1	28.4
3		Тайлант онд албан хаагчдад илүү цагийн хөлс тооцож олгох хуудас хөтөлж баталгаажуулаагүй 2,252.4 мянган төгрөгийг олгосон байна.	1	2.2							1	2.2
Дүн			3	31.3					1	0.7	2	30.6
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	Хайрхан сумын СТөв	МУЗГ-ын 43 дугаар тогтоолын хэрэгжилт 9.5% буюу 3.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна	1	3.7					1	3.7		
2		Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 109 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 41 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1						1			
Дүн			2	3.7					2	3.7		
Нийт дүн			5	35					3	4.4	2	30.6

